ТАНИЛЦУУЛГА

2024.11.20-ны өдөр

Нийслэл Улаанбаатар хотод нүүрстөрөгчийн хий ялгарлыг
цэвэр эрчим хүчээр солих замаар хүлэмжийн хийг бууруулах
талаар авах зарим арга хэмжээний тухай

Нийслэл Улаанбаатар хот нь Монгол Улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг ч нийт хүн амын 48.7 хувь нь амьдарч, хүн амын хэт төвлөрөл үүссэнээс нийгэм эдийн засаг, хот төлөвлөлт, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд олон талын сөрөг үр дагавар үүсгэсний нэг хүчин зүйл нь уурын зуухны түүхий нүүрсний хэрэглээ, гэр хорооллын өрхүүдийн ядангийн утаа, хуучин авто машинаас гарч байгаа агаарт хүхэрийн хэт исэл нүүрстөрөгчийн хий ялгаруулж байгаа асуудал юм.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо сүүлийн 10 жилийн хугацаанд 310,000 буюу 27%-иар нэмэгдсэн ба шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдал дээр тооцоолоход 2030 он гэхэд нийслэлийн хүн амын тоо 2,591,824 хүрэх төлөвтэй байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2.41, 4.2.42 дахь заалтын хүрээнд 2021-2030 онд эрчим хүчний салбарт инновац, дэвшилтэт техник, ухаалаг технологи болон шинэ эх үүсвэрийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай, бие даасан, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхээр зорилт тавьсан.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлнэ” зорилтыг хэрэгжүүлэх 1.1.2.1, 1.1.2.2 дахь үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах хийн дулааны станцууд болон хотын дэд төвүүдийн дулааны станцуудыг үе шаттайгаар барина.”, “Нийслэл хотод бие даасан, тархмал цахилгаан, дулааны эх үүсвэрийг байгуулж, суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлнэ” зэргийг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Мөн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 4.2.7 дахь үйл ажиллагааны хүрээнд “Хот, суурин газрын дулааны хангамж, шугам сүлжээг өргөтгөх, шинээр дулааны эх үүсвэр барих ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, нүүрсний хэрэглээ, хаягдлыг бууруулахад чиглэсэн технологийн шинэчлэл хийх”-ээр төлөвлөсөн байна.

*Агаар, орчины чанарын өнөөгийн нөхцөл байдал*

Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 хувийг гэр хорооллын айл өрхийн гэрийн зуух болон аж ахуйн нэгж, байгууллагын 3200 орчим халаалтын зуух, 10 хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа 400 мянга гаруй автотээврийн хэрэгсэл, 5-6 хувийг дулааны цахилгаан станцууд, 4 хувийг үнсэн сан, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал зэрэг бусад эх үүсвэр ялгаруулж байна.

Нийслэлийн гэр хороолол жилдээ 160-200 мянган тонн үнс хаядаг. Цахиурын исэл гэх бодис үнсний 70 хувийг бүрдүүлж, агаарт дэгдсэн тохиолдолд амьсгалын замаар дамжин хүний уушги харлах, уушгины хавдар үүсэх зэрэг өвчлөлүүдийг бий болгоход нөлөөлж байна гэсэн дүгнэлтийг 2017 онд хийсэн судалгаагаар тогтоосон байна.

Улаанбаатар хотод 1.7 сая иргэн амьдарч байгаа бөгөөд сүүлийн үед жилд дунджаар 40 гаруй мянган иргэн шинээр бүртгэгдэж байна. Ийнхүү хүн амын өсөлт, төвөлрөл нэмэгдэж, гэр хороолол тэлэх тусам хотын агаар, орчны бохирдол ихсэж, байгаль орчин төдийгүй хүний амьдрах орчин, эрүүл мэнд болон эдийн засаг, нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Гэр хорооллын агаарын бохирдол үүсгэгч хүчин зүйлийг багасгах зорилгоор өнгөрсөн жилүүдэд 153 мянган сайжруулсан зуух, 100 мянган энгийн дан зуух, ханан пийшин, 40-50 мянган ширхэг нам даралтын зуух, 3000 гаруй бүтэн шаталттай уурын зуух, гэр хорооллын амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор 60 мянган айлд сайжруулсан гэрийн эсгий туурга дулаалга, 35 мянган айлд цахилгаан яданг шинэчлэх зэрэг олон арван төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн боловч тодорхой үр дүнд хүрч, хүлэмжийн хийг бууруулж чадсангүй.

Агаар, орчны бохирдлыг бууруулах хүрээнд гэр хорооллын 60 мянган өрхийн 0,4 кВт-ын цахилгаан шугам сүлжээг шинэчлэн засварлаж, цахилгаан халаалттай айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний хэрэглээнд хөнгөлөлт олгож байгаа нь эрчим хүчний нэгдсэн системд учруулж байгаа чадлын дутагдлын 30 гаруй хувийг эзэлж байна.

Сайжруулсан *түлшний үйлдвэрлэл, хэрэглээний талаар*

Нийслэлийн хэмжээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах 7 дүүргийн 197 хорооны 203,683 гэр хорооллын айл өрх (УБЦТСХК-ны гэр хорооллын хэрэглэгчдийн тоо)-ийг сайжруулсан түлшээр хангаж байна. Тодруулбал, 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар зүүн болон төвийн бүсийн үйлдвэрээс нийт 370,186 тонн сайжруулсан түлшийг 29 тээврийн компанийн 300 гаруй жолооч тээвэрлэж, 580 гаруй гэрээт борлуулагчаар дамжуулан эцсийн борлуулалтын цэгт 167 агуулахаар дамжуулж хүргэдэг.

Нийслэл Улаанбаатар хот 2018 оноос эхлэн утаагүй шахмал, сайжруулсан түлш /цаашид “Сайжруулсан түлш” гэх/-ийг хэрэглэж, түүхий нүүрсний хэрэглээг хориглосон. Өнөөдрийн байдлаар “Таван толгой түлш” /цаашид “ТТТ” гэх/ компанийн сайжруулсан түлш үйлдвэрлэхэд зориулж өнгөрсөн 7 жилийн хугацаанд “Эрдэнэс таван толгой” /цаашид “ЭТТ” гэх/ компаниас 1,242,7 их наяд төгрөгийн санхүүжилт, тэдгээрийн тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтанд зориулж хотоос 360,0 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. Өөрөөр хэлбэл 1тонн сайжруулсан түлшийг 518,0 мянган төгрөгөөр үйлдвэрлээд 150,0 мянган төгрөгөөр иргэдэд борлуулж, зөрүү алдагдлыг ЭТТ санхүүжүүлж, борлуулсан сайжруулсан түлшний 1 тонн тутамд 10 хувийн урамшуулал, тээвэр, агуулахын зардлыг нийслэл хотоос хариуцан санхүүжүүлж байна. Сайжруулсан түлшний хэрэглээ жилээс жилд нэмэгдэж, хөдөө орон нутагт хулгайгаар гарах тохиолдол тасрахгүй байна. Сайжруулсан түлш анх 230,0 мянган тонныг жилд үйлдвэрлэж байсан бол оргил жилдээ 710,0 мянган тонн хүрсэн бөгөөд 2024 оны байдлаар 530,0 мянган тонн сайжруулсан түлшийг үйлдвэрлэж, борлуулж байна.

Сайжруулсан түлш хэрэглээ нь агаар дахь нарийн, бүдүүн ширхэгт тоосонцор /PM2,5, PM10/ 50 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа гэж дүгнэж байгаа. Гэвч бодит байдал дээр шахмал түлшний чанар, ашиглаж буй зуухны чанараас хамаарч илч муу байх, дутуу шаталт явагдах, үүний улмаас маш их агаарын тоосонцор, угаар үүсэх эрсдэл байсаар байна. Үүнээс шалтгаалж айл өрхүүд түүхий нүүрсээ түлэх явдал ч гарсаар байна. Түүхий нүүрс болон шахмал түлшнээс агаарт ялгарч буй элементүүд нь агаарын бохирдол үүсгээд зогсохгүй газарт буусны дараа хөрсний бохирдлыг нэмэгдүүлж байдгаараа улам бүр хөнөөлтэй юм.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг үүсгэж буй гол хүчин зүйл нь тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл, хүхэрлэг хий, азотын давхар исэл юм. Эдгээрийг PM10, PM2.5, SO2, CO, NO2, O3 гэсэн элементүүд бүрдүүлдэг. Тодруулбал, түүхий нүүрс, сайжруулсан түлшний хэрэглээнээс үүсэж буй тоосонцор, угаарын хий буюу PM2.5 нь уушгинд байгаа хүчилтөрөгчийг сорж авдаг сувгуудыг бөглөх, PM10 нь хүчилтөрөгч дамждаг сувгаар орж цаашаа цусанд нэвтрээд тархины ажиллагаанд нөлөөлдөг, CO нь угаартахад хүргэдэг учир хамгийн хөнөөлтэй нь юм.

Нийслэл хотын агаарын чанарын CO2 хүлэмжийн хий ялгаруултын түвшин зөвшөөрөгдөх хэмжээнээс 30,7 хувь өндөр байгаа нь хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжгүй байдал жилээс жилд муудсаар, хүний амь нас хохирсоор байна. Агаарын орчины бохирдолоос үүдэлтэй иргэдийн дунд амьсгалын замын өвчлөл жил ирэх тусам ихсэж, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учирсаар байна.

Нөгөөтэйгүүр *Нийслэл Улаанбаатар хотын нэгдсэн* дулаан хангамжаас үүдэлтэй хэт төвөлрөл үүсч, бетон ширэнг үүссэн. Улаанбаатар хотын дулааны эрчим хүч үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадлыг боломжит хэмжээгээр тооцоход 2318 Гкал/ц байгаа бөгөөд төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон хэрэглэгчдийн халааалтын улирлын дулааны нийт тооцоот ачаалал 3403.1 Гкал/ц, техникийн нөхцөлийн хүлээгдэж буй дулааны тооцоот ачаалал 474.53 Гкал/ц байна. Өөрөөр хэлбэл эх үүсгүүрүүдийн суурилагдсан хүчин чадлаас 1085.3 Гкал/ц буюу 46%-иар хэтэрсэн үзүүлэлттэй байна. Энэ жилээс эхлэн хотын дулаан хангамжийн систем доголдож байгаа энэ үед тархмал бие даасан дулааны эрчи хүчийг барьж байгуулахгүй тохиолдолд аваарийн байдал үүсч болзошгүй байна.

Нийслэл Улаанбаатар хотын дулааны хэрэглээг цэвэр, эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй байлгах, харьцангуй богино хугацаанд агаар бохирдлыг бууруулахын тулд Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан дэлхийн хотуудын жишиг, олон жил туршигдсан, цэвэр эрчим хүчний шинэ эх үүсвэр болох хийн түлш, сэргээгдэх эрчим хүч зэрэг бодит техник технологийг нэвтрүүлэх ажлыг оновчтой тусган төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллага /цаашид “НҮБ” гэх/-ын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвинцийг хэрэгжүүлэгч талуудын 29 дахь удаагийн COP29 хуралдаан Азарбажиан улсын нийслэл Баку хотод яг энэ цаг үед зохион байгуулагдаж байна. Энэ удаагийн уулзалтаас НҮБ нь олон улсад нүүрстөрөгчийн кредитийг арилжаалдаг зах зээлийг бий болгох шинэ стандартыг баталсан байна. Өөрөөр хэлбэл хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нүүрстөрөгчийн хийн кредит тооцох дүрэм гарсан байна. Ингэснээр улс орнууд өөрсдийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах санаачлагыг өндөр хөгжилтэй улс оронууд санхүүжүүлэх бөгөөд нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулсан тонн тутамыг олон улсын зах зээлд арилжах чухал алхам болж байна.

Нүүрстөрөгчийн кредит буюу хүлэмжийн хийг бууруулсан тонн тутамд кредит олгох замаар хүлэмжийн хий их хэмжээгээр ялгаруулаг улс орнууд төлбөр олгодог байх 2015 онд байгуулсан уур амьсгалын өөрчлөлтийн Парис гэрээний 6 дугаар зүйлд заалтыг хэрэгжүүлэх зорилгоор улс орнууд нүүрс төрөгчийн кредитийг тооцож харилцан арилждаг дүрэм батлагдсан нь манай оронд нэн таатай нөхцөл байдал үүсч байна.

Бидний зүгээс сайжруулсан түлш болон түүхий нүүрсний хэрэглээг цэвэр эрчим хүчээр солих замаар богино хугацаанд багасгаж, агаар орчиныг бохирдуулж байгаа нүүрстөрөгчийн хий ялгаралын хэмжээг буулгаж, хүлэмжийн хийн кредитээс тодорхой орлого олж, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх боломж байна. Өнөөдөр улс орнууд харилцан адилгүй байдлаар Нүүрстөрөгчийн кредит цуглуулж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулсан 1 тонн тутамд олон улсад хамгийн бага нь 5 ам.доллороор, хамгийн өндөр нь 70-80 ам.долларoор арилжигдаж байна. Энэ дүрэм батлагдсанаар 1 тонн тутамд нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах 1 кредитын хэмжээ 100 ам.доллар давах хандлагатай байгааг олон улсын шинжээч нар дүгнэсэн. Өнөөдрөөс эхэлж, хүлэмжийн хийг бууруулах эсвэл түүнээс зайлсхийх арга замыг эрэлхийлж олон улсад харуулах цаг хугацааны тохирол бүрдлээ.

Энэ нь нүүрстөрөгчийн хий ялгаруултыг тархмал эрчим хүчний шинэ эх үүсвэр буюу цэвэр эрчим хүчээр солих замаар хүлэмжийн хийг бууруулах тодорхой шийдэл бүхий олон улсад туршигдсан, дэвшилтэт технологи бүхий өөрсдийн нөөцийг ашиглан нэн даруй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж үүнээс гарсан үр дүнг олон улсад арилжиж хөрөнгө оруулалт босгох боломжийг олж авах нэн шаардлагатай байна

Хүний эрүүл мэндэд шууд хор хөнөөл учруулж буй энэ үзүүлэлтийг бууруулах нь агаар, орчны бохирдлыг бууруулах цэвэр эрчим хүчний шинэ эх үүсвэрийн төсөл, хөтөлбөрийн гол зорилт нь байх учиртай юм.

*<u>Цэвэр эрчим хүчний нэг төрөл хийн түлш буюу шингэрүүлсэн нефтийн хийн (LPG) давуу тал</u>*

Дэлхийн ихэнх хотууд шингэрүүлсэн нефтийн хий (LPG) -г дулааны эрчим хүчний эх үүсвэрээр сонгож, цэвэрхэн, аюулгүй, хүртээмжтэй, утаа тортог ялгаруулахгүй, хөрс, ус, гүний усанд хортой нөлөө үзүүлэхгүй, бүрэн шаталттай уламжлалт түлшнээс 5 дахин илүү үр ашигтай болохыг хэдийн нотолсон Иймд сайжруулсан түлшний хэрэглээг хийн түлшинд шилжүүлэх төслийг хэрэгжүүлэх замаар Улаанбаатар хот, цаашлаад хөдөө орон нутгийн аймгийн төвийн агаарын бохирдлыг бүрмөсөн шийдвэрлэх, улмаар хөрсний бохирдлыг бууруулах боломж байна.

Урьдчилсан тооцооллоор уг төслийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд нийслэлийн хэмжээнд 203,000 өрх гэр хороололд амьдардаг /УБЦТСХК-ны гэр хорооллын хэрэглэгчдийн тоо/ гэж үзвэл 2027-2028 оны өвлийн их ачаалал эхлэхээс өмнө 120,0 мянга айл өрхийн эрчим хүчний хэрэглээг хийн түлшинд шилжүүлж, гэр хорооллын одоогийн утааг 50 хувиар бууруулж, хүлэмжийн хий ялгаруулсан байдлыг энэ хэмжээгээр буулгасан кредит цуглуулж олон улсад арилжиж, дараа дараачийн төслийн хөрөнгө оруулалтын санг үүсгэх зорилготой.

Эхний шатанд Дарь-Эх, Баянхошуу орчмын 15,0 мянган өрхөд жишиг байдлаар суурилуулах ажлыг 2025 онд, дараагийн шатанд Сэлбэ, Дамбадаржаа орчмын 40,0

мянган айл өрхийг 2026 онд, гурав дахь шатанд дэд төвүүдийг түшиглэсэн 45,0 мянган айл өрхийг хамрагдуулахаар тооцоолол хийгээд байна. Зохион байгуулалтын хувьд өрх бүрд хийн төхөөрөмжийг суурилуулах эсвэл хэсэгчилсэн хийн жижиг станцыг нэгдсэн байдлаар холбох, зарим өрхийг хийн түлшээр ажилладаг дулааны эх үүсвэрээс хангах бие даасан байгууламж хэлбэрээр хэрэгжүүлэх хувилбар боловсруулад ажиллаж байна.

Байгуулах үеийн өртөг зардлын хэмжээг аваад үзвэл хийн түлш түгээх нэг дэд төв нь 200-300 айл өрхийн хэрэгцээг хангах чадалтай 5 тонн шингэрүүлсэн хий хадгалах танк, хийн түлш түгээх нэгдсэн шугам хоолой болон бусад шаардлагатай аюулгүй байдлыг хангах тоноглол зэрэг багтсан байгууламжийн өртөг нь 60,000-70,000 ам.доллар байна.

Айл өрхөд суурилуулах зардал нь 100 мкв-аас байшинд 1,000 ам.доллар, 100 мкв-аас дээш байшинд 1,500 ам.доллар, монгол гэрт 500 ам.доллар байх жишиг өртөгтэй. Үүнийг хийн түлш борлуулагч хувийн хэвшлийн оролцоог хангах замаар шийдвэрлэх бүрэн боломжтой юм. Ашиглалтын зардлыг халаалтын 7н сарын үед дундаж хэрэглээтэй өрхөд тооцоход 900 орчим кг хийн түлш буюу 1кг хийн түлшний үнийг 2900 төгрөгөөр тооцоход 2,4 сая өгрөгтэй байхаар байна. Өрхийн сарын дундаж хэрэглээ 500,0 орчим мянган төгрөг байгаа нь хийн түлшийг хүр бүр хэргэлэх боломжгүй байгаа тул үүнийг ЭТТ-оос сайжруулсан түлшинд олгодог санхжүүлтээс олгох тохиолдолд хийн түлшний хэрэглээ нэмэгдэж, энэ хэмжээгээр сайжруулсан түлшний хэрэглээ буурна.

Нэгдсэн хийн түлшний системийг нэвтрүүлснээр өрх бүр бие даасан байдлаар тавьсан хийн түлш ашиглалтын зардал 24.5% багасах ба эрчим хүч ашиглалтын зардал, LPG баллон, туслах материалын хэрэглээ болон хяналтын зардал багасах төдийгүй баллон байнга солих, сэлбэг солих, аюулгүй байдлыг өдөр тутамд шалгахтай холбоотой цаг хугацаа, хөдөлмөрийн бүтээмж сайжирна. Үүний дээр хийн түлш ашиглалтын аюулгүй байдлын үнэлгээ өсөж, баллон цэнэглэх, ачиж буулгах, солих үеийн эрсдэл багасах, хэрэглэгчийн сэтгэл ханамж 94.1% өсдөг байна.

Хийн түлшийг ашигласнаар аль ч хувилбарт орон байрыг халаалт, халуун усаар хангахаас гадна хоол хийх боломж бүрдэх бөгөөд эдийн засгийн хувьд үр ашигтай, эрчим хүчинд хэмнэлттэй, байгаль орчин, хүний эрүүл мэнд, амьдралын чанарт шууд эерэг нөлөө үзүүлэхээс гадна дам эерэг үр дагавар олон юм.

Шахмал түлшний хэрэглээг хийн түлшинд шилжүүлэх төсөл нь харьцангуй богино хугацаанд агаар, орчны бохирдлыг бодитой хэлбэрээр бууруулах олон улсад туршигдсан технологи бөгөөд техник, технологи, хөрөнгө санхүү, хүний нөөцийн бүхий л боломжийг ашиглан салбар дундын нэгдсэн зохицуулалтыг ханган хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Төсөл, хөтөлбөрийн зорилт, агуулга

Төслийн зорилго нь олон улсад туршигдсан тархмал эрчим хүчний шинэ эхүүвэр буюу цэвэр эрчим хүчний дэд бүтцийг бий болгох, төр, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, донор хандивлагч олон улсын орнуудын хөрөнгө оруулалт, зээл тусламжийг ашиглах, хүлэмжийн хийг бууруулсан кредитийг цуглуулж олон улсад арилжаж хөрөгө санхүүжилт олох, эрчим хүчний салбарын хязгаарлагдмал нөөцийг хэмнэж, төвийн эрчим хүчний хэрэглээг бууруулж, энэ салбарт үүсдэг хуримтлагдсан

алдагдал, чадлын ачааллыг багасгах замаар агаар, орчны бохирдлыг бууруулж, нүүрстөрөгчийн хий ялгаруулдаг хүчин зүйлсийг хориглох явдал юм.

*Хүрэх үр дүн*

1. Эрчим хүчний салбарт халаалтын өвлийн улиралд үүсдэг чадлын хэрэгцээний дутагдлыг 30% бууруулах боломжтой.
2. Цахилгаан эрчим хүчний шөнийн хэрэглээг “0” холбоотой үүсдэг хуримтлагдсан алдагдлыг хэмжээг бууруулах боломжтой.
3. Төвийн эрчим хүчний системд оройн ачаалалд 116МВт дутагдаг ордог бөгөөд ОХУ-аас 3100 МВт-ыг өндөр үнэтэй худалдан авдаг үнийн зөрүүний алдалгыг буурулах боломжтой. Мөн аж ахуйн нэгж, айл өрхийн цахилгааны эрчим хүчний хэрэглээг багасгах боломжтой. .
4. Нүүрсхүчлийн хий буюу CO2-ыг хэмжээ бууруулж, агаарын чанарыг сайжруулснаар хүрээлэн буй орчны бохирдол чанараас үүдэлтэй өвчлөл, хүний амь нас эндэгдэл буурна.
5. Айл өрхүүд дулааны эрчим хүчний хэрэглээгээ өөрөө зохицуулах, хянах, дулаан алдагдлаа бууруулах хариуцлага дээшилж, хог хаягдал багасаж эдийн засагт дам нөлөөгөөр хэмнэлт үүснэ.
6. Хүний амьдрах орчин цэвэрхэн болж, хөдөлмөрийн цаг зарцуулалт багасаж, амьдралын орчин сайжирна.
7. Хийн түлшний хэрэглээ нэмэгдсэнээр ирээдүйд урт хугацаанд нүүрсийг гүн боловсруулж, нүүрснээс шингэрүүлсэн хийн гаргаж авах хувийн хэвшлийн идэвхи санаачлага төрж, бизгесийн орчин нэмэгдэнэ. Мөн байглийн хий болон энэ төрлийн нийлүүлэлт хийх үйлдвэрлэл хөгжиж эхлэнэ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР